



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, эцэс нь
оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт №1



НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ДҮРЭМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль / цаашид “сургууль” гэх/-ийн зорилго, үндсэн чиг үүрэг, сургуулийн үйл ажиллагаатай холбоотой зарчим, бүтэц зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо, тэдгээрийн бүрэн эрх, үүрэг, хариуцлагын харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Сургууль нь Монгол Улсын үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 1.3 Сургуулийг Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль / англиар “University of Social and Psychology of Mongolia” гэж албан ёсоор нэрлэх ба Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, Нарны зам 16/4 хаяг дахь өөрийн байранд байрлана. Утас: /976/-11-301489
- 1.4 Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн эрхэм зорилго нь “Нийгмийн хөгжилд өндөр оролцоотой, хүнлэг, ёс суртахуунтай мэргэжилтэн бэлтгэнэ”.
- 1.5 Сургуулийн үндсэн зорилт нь Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталж гаргасан стандарт, хөтөлбөрийн дагуу оюутанд дээд боловсрол эзэмшүүлэх, салбар шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгаа эрхлэн шинэ мэдлэг бүтээх, хүн амд мэдлэг түгээх, боловсрол, соёлын төвшинг дээшлүүлэхэд оршино.
- 1.6 Сургууль тогтоосон журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, өөрийн бэлэгдэл /эмблем, туг/-тэй байна.

Хоёр. СУРГУУЛИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

- 2.1. Сургуулийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.14, 17 дугаар зүйлд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцох ба Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хуульд заасан шаардлагын дагуу тухай бүр авч зйл ажиллагаагаа явуулж байна.



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт №1

2.2. Сургууль нь энэхүү дүрмийг батлах үеийн тусгай зөвшөөрлийн дагуу сургалт, үйл ажиллагааны чиглэлүүдээр бакалаврын зэрэг олгох өдөр, орой, эчнээ сургалтыг явуулж буй бөгөөд цаашид тусгай зөвшөөрөл, боловсролын зэргийг ахиулан өргөтгөж үйл ажиллагаа явуулж болно.

2.3. Сургуулийн дүрэм болон дүрмийн 4.3-т заасан чиглэл, зөвлөмжид нийцүүлэн сургуулийн үйл ажиллагааны нарийвчилсан дотоод журам гаргаж мөрдүүлэх ажлыг сургуулийн захиргаа хариуцаж гүйцэтгэнэ.

2.4 Сургууль нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай гэрээ хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүх, хөндлөнгийн шүүхэд нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцох эрхтэй.

2.5. Сургууль нь хүлээсэн үүргийнхээ хувьд эд материалын хариуцлагыг зөвхөн дүрмийн сангийн хэмжээнд хариуцна.

2.6 Сургууль нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд өөрийн салбар, төлөөлөгчийн газруудыг байгуулж болно.

2.7 Сургууль нь харьяалалдаа мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвтэй байж болно. Зарим мэргэжлээр шаталсан сургалт зохион байгуулах, мэргэжлийн тэнхимүүдээрээ дамжуулан зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлж болно.

2.8 Дээд боловсролын сургалтыг байгууллага болохын хувьд хамтарсан болон дагнасан сургалт-эрдэм шинжилгээний зориулалт бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний түшиц байгууллага, лаборатори дадлагын бааз, туслах аж ахуйтай байж болно.

Гурав. СУРГУУЛИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ

3.1 Сургуулийн үндсэн чиг үүрэг нь бакалаврын зэрэг олгох сургалт эрхэлж иргэнд дээд боловсрол эзэмшүүлэх, шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа эрхлэн шинэ мэдлэг бүтээх, мэдлэгээ практикт хэрэгжүүлэх чадвартай, нийтэд мэдлэг түгээх, боловсрол соёлын түвшнийг нь дээшлүүлэхэд оршино. Энэхүү чиг үүргийн хүрээнд доорх сургалтын үйл ажиллагааг явуулна. Үүнд:

3.1.1. Монгол улсад сэтгэл судлал, нийгмийн шинжлэх ухааныг эрчимтэй хөгжүүлж, сэтгэл судлалын шинжлэх ухааныг хэрэглээнд ойртуулах замаар нийгмийн бүхий л салбарт дэлгэрүүлж үр өгөөжийг нь дээшлүүлэх;



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

3.1.2. Бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд буюу амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх боловсролын зорилгыг дээдэлсэн, ёс зүйтэй багш бэлтгэх;

3.1.4. Хэл шинжлэлийн ухааныг эрчимтэй хөгжүүлж, улс үндэстнүүдийн дэвшилтэт соёл хөгжлийг нутагшуулж, зан заншлаас суралцах, Монгол залуу хүнийг дэлхийн түвшинд гарах суурь бэлтгэл болох эх хэлээ сайн эзэмшсэн хэл шинжлэлийн мэргэжилтэн болгоно.

3.2 Энэхүү дүрэмд дурьдсан зорилгодоо хүрэхийн тулд доорх зорилтыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. Сургуулийн сургалтын арга барилд олон улсын шалгарсан аргыг нэвтрүүлэх;

3.2.2. Практикт тулгуурласан мэргэжил олгох бодлогыг баримталж ажиллах;

3.2.3. Чадварлаг багш нараар баг бүрдүүлэх, багшийн мэдлэг, багшлах ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх бодлогыг баримтлах;

3.2.4. Элсэгчдийн чанарт тавих стандарт шаардлагыг жил бүр нэмэгдүүлэх; түүнчлэн суралцагчдад орчин үеийн хамгийн шилдэг сургалтын хөтөлбөрийг санал болгох замаар дэлхийн стандар шаардлагад нийцсэн чанартай боловсрол олгох;

3.2.5. Сургуулийн эцсийн бүтээгдэхүүн болох төгсөгчид нь Монгол Улсын буюу олон улсын тухайн салбарын чанарын шаардлага, стандартын түвшинг хангаж чадах боловсролтойн дээр тухайн очсон газартаа хөгжил дэвшил, эерэг уур амьсгал /орчин/ бүрдүүлж чадах зөв хүн болгоход анхаарна.

3.3. Сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, өдөр тутмын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:

3.3.1. Хуулийг дээдлэх зарчимд тулгуурлан чиг үүргээ хэрэгжүүлэх;

3.3.2. Боловсролын үйлчилгээний чанарын баталгааг хангах;

3.3.3. Эрдмийн эрх чөлөөг хангаж хамгаалах;

3.3.4. Хувь хүний чөлөөт хөгжлийг дэмжих, хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийн үнэ цэнэт зүйлс, ёс зүйн зөв хүмүүжлийг суралцагчдад төлөвшүүлэх;

3.3.5 Сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн нэгдлийг хангах.

Дөрөв. СУРГУУЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

4.1 Сургуулийн үйл ажиллагааны бодлого, стратегийн холбогдолтой, нийтлэг асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үүсгэн байгуулагч буюу хөрөнгө оруулагч батлах ба өөрийн төлөөллөөрөө дамжуулан дээд сургуулийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж чиглүүлнэ.

4.2 Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч нь сургуулийн дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, зөвлөлийг холбогдох хууль, энэхүү дүрмийн дагуу томилж, чөлөөлөх, Удирдах зөвлөлийн даргаар сонгогдох давуу эрх, сургуулийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг олгох, олгогдсон бүрэн эрхээ хэсэгчлэн болон бүгдийг бусдад шилжүүлэх, итгэмжлэх, сургуулийн захирлыг томилох, чөлөөлөхөд санал өгөх, Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын ажлын тайлан, сургуулийн санхүүгийн болон үйл ажиллагаатай нээлттэй танилцах, шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачлагаар сургуульд аудит оруулах зэрэг бүрэн эрхийг эдэлнэ.

4.3 Бакалаврын болон шаталсан сургалт явуулахад нэн тохиромжтой цогцолбор бүтэц, удирдлагын шинэлэг зохион байгуулалтын талаар үүсгэн байгуулагч буюу хөрөнгө оруулагч нь өөрийн туршлага, олон улсын жишигт тулгуурлан тодорхой чиглэл, зөвлөмжийг сургуулийн захиргаанд өгөх эрхтэй.

4.4 Үүсгэн байгуулагч нь энэхүү дүрэмд зааснаас бусад байдлаар хууль бус үйлдлийг шаардах, өдөр тутмын үйл ажиллагаанд хөндлөнгөөс орохыг хориглоно.

4.5 Сургууль нь өөрийн үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах нөхцлийг бүрэн дүүрэн хангасан зохион байгуулалт, бүтцийн нэгжтэй байна. Сургуулийн зохион байгуулалтын бүтцэд дараах үндсэн нэгжүүд орно. Үүнд:

4.5.1 Удирдах зөвлөл

4.5.2 Сургуулийн захирал

4.5.3 Захирлын зөвлөл

4.5.4 Эрдмийн зөвлөл

4.5.5 Сургалтын алба

4.5.6 Сургалт заах арга зүйн зөвлөл

4.5.7 Мэргэжлийн тэнхимүүд

4.5.8. Хөтөлбөр, ЧДБА

4.5.9. Санхүү аж ахуйн алба



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

- 4.6 Сургуулийн үүсгэн байгуулагч, Удирдах зөвлөл нь тус сургуулийг удирдах бүрэн эрхээ хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр өөр мэргэжлийн багт /Менежментийн баг/ тодорхой хугацаагаар гэрээний дагуу шилжүүлж болно.

Тав. СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 5.1. Сургууль нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд тус зөвлөл нь сургуулийн өөрийн удирдлагын дээд байгууллага мөн.
- 5.2. Удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд: Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн төлөөлөл, боловсролын чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, менежментийн баг байгаа тохиолдолд тус багийн ахлагч, сургуулийн захирал, мөн багш, суралцагч, төгсөгчдийн төлөөллөөс тус тус бүрдэнэ.
- 5.3. Удирдах зөвлөлийн дарга нь үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч байна.
- 5.4. Сургуулийн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа нь Удирдах зөвлөлийн хурал байна. Удирдах зөвлөлийн хурал нь үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчаас баталсан Удирдах зөвлөлийн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах боловч энэхүү дүрэмд заасан дараах нийтлэг бүрэн эрхийн хүрээнд ажиллана.
- 5.4.1. Сургуулийн хөгжлийн бодлого, мастер болон бизнес төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулан хэлэцэж батлах
- 5.4.2. Сургуулийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчид хүргүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагад тайлбар хийх
- 5.4.3. Сургуулийн хөдөлмөрийн харилцааны бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлж, ажиллагсдын цалингийн сан, тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөр, дотуур байрны төлбөр, тэдгээрийн өөрчлөлт зэрэг төсвийг батлах
- 5.4.4. Сургуулийн тухайн хичээлийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлантай танилцах, хяналт тавих
- 5.4.5. Сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх асуудлыг зохион байгуулан хэлэлцэж, батлах, гэрээ байгуулах, удирдлагаар хангах

- 5.4.6. Сургуулийн хөгжлийн бодлого, мастер болон бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, боловсронгуй болгоход заавар, зөвлөмжийг өгөх, хяналт тавих
- 5.4.7. Сургуулийн санхүү болон мэргэжил, сургалтын үйл ажиллагаа, хүний нөөцийн чадавхийг үнэлэх зэрэг асуудлаар дотоод болон хөндлөнгийн аудит оруулах,
- 5.4.8. Сургуулийн тухайн хичээлийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлантай танилцах, гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж зүгнэх, хариуцлага, урамшууллыг олгох
- 5.4.9. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлангаа хэлэлцэж баталгаажуулан, үүсгэн байгуулагч хөрөнгө оруулагчид хүргүүлж дүгнүүлэх
- 5.4.10. Сургуулийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хэлэлцэн батлах, шаардлагатай гэж үзвэл гүйцэтгэх захирлаас өргөн мэдүүлсэн бусад журмыг хэлэлцэж санал оруулах, зөвлөгөө өгөх эрхтэй.
- 5.5. Удирдах зөвлөл нь сургуулийн үйл ажиллагаа, чанар, стандартыг ахиулах, хөгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагч хөрөнгө оруулагчийн бичгэн зөвшөөрлийг үндэслэн сургуулийн удирдлага менежментийн эрхийг хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр, тодорхой хугацаатай, гэрээний дагуу мэргэшлийн багт шилжүүлж болно.
- 5.6. Менежментийн гэрээг энэхүү дүрмийг удирдлага болгон үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч баталгаажуулна.

Зургаа. СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

- 6.1. Сургуулийн удирдлага, зохион байгуулалтын ажлын хүрээнд захирал сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллана.
- 6.2. Захирал нь сургуулийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр олгосон эрх хэмжээ болон Удирдах зөвлөлөөс өөртэй нь байгуулсан гэрээнд заагдсан эрх, үүргийн хүрээнд удирдан зохион байгуулж ажиллана.
- 6.3. Сургуулийн захирал нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6.3.1. Сургуулийн өдөрт тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
- 6.3.2. Сургуулийн хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, дээд сургуулийг төлөөлөн ажиллагсадтай Хөдөлмөрийн тухай хууль болон Иргэний хуулийн дагуу гэрээ байгуулах, гэрээ, ажлын гүйцэтгэлийг дүгнэх, сахилгын шийтгэл оногдуулах, гэрээ цуцлах
- 6.3.3. Ажиллагсад /багш, ажилтан/-ын ажлын байрны тодорхойлолтыг батлах
- 6.3.4. Сургуулийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад үйл ажиллагааны дүрэм, журмыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд баталж, мөрдүүлэх
- 6.3.5. Сургуулийн гадаад, дотоод харилцааг хөгжүүлэх, холбогдох асуудлаар гэрээ байгуулах, үр дүнг үнэлэх
- 6.3.6. Удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, ажлын байрны тодорхойлолт, тухай бүр даалгасан үүргийг хэрэгжүүлэх
- 6.3.7. Сургуулийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг Удирдах зөвлөлд тайлагнах
- 6.3.8. Сургуулийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах
- 6.3.9. Батлагдсан мастер болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- 6.3.10. Сургуулийн бүтэц зохион байгуулалт, цалингийн сангийн талаар Удирдах зөвлөлд санал оруулах
- 6.3.11. Сургуулийн элсэлтийн үйл ажиллагааг тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хүрээнд ханган ажиллах, төлөвлөгөөт болон тоон зорилт түүнийг хангаж ажиллах
- 6.3.12. Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд төсвийг захиран зарцуулах
- 6.3.13. Холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Удирдах зөвлөлийн хуралд оруулах
- 6.3.14. Захирал өөрийн бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

6.3.15. Захирлын зөвлөлийг байгуулах, түүний дүрмийг боловсруулж Удирдах зөвлөлд оруулах

6.3.16. Эрдмийн зөвлөлийг удирдаж ажиллах

6.3.17. Оюутныг элсүүлэх, сургах, төгсгөх журам батлах

6.3.18. Хууль болон гэрээгээр хүлээсэн бусад бүрэн эрх, үүрэг.

Долоо. ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

7.1. Сургуулийн захирал өөрт ноогдсон үүргийг амужилттай хэрэгжүүлэхдээ туслалцаа вах, оновчтой шийдвэр гаргах үүднээс өөрийн эрхийн хүрээнд сургуулийн Захирлын зөвлөлийг байгуулж ажиллаж болно.

7.2. Захирлын зөвлөл нь сургуулийн удирдлага, бэтгэц, зохион байгуулалтын үндсэн чиглэл, функцын нэг байна.

7.3. Захирлын зөвлөлийн ажиллах дүрэм, журмыг Захирал боловсруулж батална.

7.4. Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнд Захирал, Сургалтын албаны дарга, Захиргаа, аж ахуйн албаны дарга, Хөтөлбөрийн хорооны удирдагч нар багтах бөгөөд Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг протоколоор баталгаажуулан шаардлагатай зүйлийг Захирлын тушаалд тусгана.

7.5. Сургуулийн Захирлын зөвлөл дарах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

7.5.1. Их, дээд сургуулиудын бэлтгэн гаргадаг мэргэжлийн хөтөлбөрийн чиглэл тус бүрээр ирээдүйн хандлагын судалгааг хэлэлцэх

7.5.2. Тухайн бэлтгэн гаргаж буй мэргэжлийн сургалтын чанар болон зах зээлийн судалгаа, шинжилгээ хийх

7.5.3. Сургалтын стандартыг судалж, дүн шинжилгээ хийх, дүгнэлтийг хэлэлцэх



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

7.5.4. Сургалт заах арга зүйн зөвлөлийн үйл ажиллагааны журам, Сургалтыналбаны ажиллах журам, Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны журмыг тус тус хэлэцэн батлах

7.5.5. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар сургуулийн захиралд санал зөвлөмж өгөх, хэрэгжилтийн явцад хамтран үүрэг хүлээж ажиллах

7.5.6. Багшийг ажилд авах сонгон шалгаруулалтын үр дүнтэй танилцаж, батлах

7.5.7. Бизнес төлөвлөгөө, Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ өгөх

7.5.8. Сургуулийн төлөвлөгөөт зорилт, сургалт, эрдэм шинжилгээ, санхүү, аж ахуйн үйл ажиллагааны явцад үнэлэлт, дүгнэлт өгч, санал гаргах

7.5.9. Захирлын эрхийн хэмжээнээс хэтэрсэн асуудлаар анхан шатны хэлэлцүүлгийг хийж дээд шатны байгууллагад танилцуулах

Найм. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ

8.1 Сургуулийн сургалт-эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үндсэн чиглэлийн хүрээнд Эрдмийн зөвлөл ажиллана. Эрдмийн зөвлөлийн ажиллах журмыг сургуулийн Захирлын зөвлөл боловсруулж, Удирдах зөвлөл батална.

8.2 Эрдмийн зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд: Эрдмийн зөвлөлийн дарга /сургуулийн захирал/, дэд дарга /эрдмийн зэрэг цолтой хараат бус зөвлөх/, гишүүд /Хөтөлбөрийн хорооны удирдагч нар болон сургуулийн эрдмийн зэрэг цолтой багш нар /байна.

8.3 Сургуулийн Эрдмийн зөвлөл нь дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ. Үүнд:

8.3.1. Сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээний чиг хандлагыг тогтоох

8.3.2. Сургалтын чанар, хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, стандартыг ахиулах арга хэмжээ авах



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

8.3.3. Сургалт арга зүйн зөвөлгөө өгөх

8.3.4. Сургалтын стандартыг судалж, дүн шинжилгээг хэлэлцэх

8.3.5. Сургуулийн эрхлэгч, багш нарын аттестатчилах журмыг боловсруулан хэлэлцэж захиралд санал оруулах, тушаалаар батлуулах

8.3.6. Хөтөлбөрийн хорооны удирдагч, багш нарын аттестатчлалыг 2 жил тутамд хийх

8.3.7 Багшийн албан тушаалд тавигдах шаардлага, гүйцэтгэх сургалт, судалгаа, нийтэд үйлчлэх ажлын ачааллын хэмжээ ба түүнийг тооцох журмыг батлах

Ес. СУРГАЛТ, ЗААХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨЛ

9.1 Сургуулийн сургалт, заах арга зүйн хүрээнд Сургалт, заах арга зүйн зөвлөл ажиллана.

9.2 Захирлын зөвлөлөөс баталсан дүрмийн дагуу Сургалт заах арга зүйн зөвлөл ажиллана.

9.3 Сургалт заах арга зүйн зөвлөл нь 5-аас ихгүй гишүүнтэй байх ба дарга, гишүүд Тэнхимийн эрхлэгч нар байна.

9.4 Нийт Хөтөлбөрийн хорооны удирдагч нарын тоо 5-д хүрэхгүй тохиолдолд багш нарын хурлаар сонгодсон үндсэн багш нарыг 3жилийн хугацаагаар сонгоно.

9.5 Сургалт заах арга зүйн зөвлөл нь дор дурьдсан чиг үүрэгтэй байна. Үүнд:

9.5.1. Багш, оюутны ёс зүйн дүрмийн мөрдөлтийг хангуулах

9.5.2. Багшийн багшлах арга барил, стандартыг бий болгох, мөрдүүлэх

9.5.3. Багшийн багшлах ур чадварыг сайжруулах, сургалт зохион байгуулах

Арав. СУРГАЛТЫН АЛБА

10.1 Сургуулийн сургалтын чанар, стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд сургалтын алба ажиллаж, улмаар сургалтын үйлчилгээний чанарт хяналт тавьж ажиллана.

10.2 Захирлын зөвлөлөөс баталсан журмын дагуу Сургалтын алба ажиллана.



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

10.3 Сургуулийн Сургалтын алба нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

10.3.1. Сургалтын графикт төлөвлөгөө гаргах

10.3.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих

10.3.3 Сургалтын чанарт хяналт тавих

10.3.4. Сургалтын төлөвлөгөө мэргэжил бүрээр гаргаж, Сургуулийн Эрдмийн зөвлөлийн даргаар батлуулах,

10.3.5 Жил бүрийн төгсөгчдийн номыг гаргах

10.3.6. Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхижүүлэх

10.3.7. Мэргэжлийн тэнхимийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлгээ өгөх

10.3.8. Багш нарын кредит цагийн тооцоог хянах

10.3.9. Сургуулийн сургалтын хөтөлбөрийг магадланд өгөх

10.3.10. Оюутны бичиг хэргийг хөтлөх

10.3.11. Элсэлт төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах

10.3.12. Шинээр элсэгчдийн тоог БШУЯ-аас баталсан тоонд хүргэж ажиллах

10.3.13. Сургуулийг Аттестатчлалд бэлтгэх

10.3.14. Сургуулийг Магадлан итгэмжлэлд бэлтгэх

10.3.15. Жил бүр ахиц дэвшлийн тайланг гаргаж, холбогдох төийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх

10.3.16. Тэнхимийн эрхлэгчийн ажлын байрны тодорхойлолтын саналыг гаргаж захиралд танилцуулах, батлуулах



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

10.3.17. Сургалтын албаны чанарын удирдлага а/ Оюутны сургалтын чанар б/ Сурах орчны чанар в/ Багш ажилтны ёс зүй г/ Сургалтын стандартын шаардлагыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх

10.3.18. Оюутны клуб, дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжиж, оролцох

Арван нэг. СУРГУУЛИЙН ТЭНХИМ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

11.1 Удирдлага, зохион байгуулалтын ажлын хүрээнд сургууль нь мэргэжлийн чиглэлийн онцлог, сургалт, олон нийтийн ажлын цар хүрээнээс хамааран мэргэжлийн тэнхимүүдтэй байна.

11.2 Тэнхим нь сургалт-эрдэм шинжилгээний үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх гол төв байна.

11.3 Сургуулийн дүрэм, журмын хүрээнд тэнхим үйл ажиллагаагаа зохион байгуулах бөгөөд дараах нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ Үүнд:

11.3.1. Мэргэжлийн хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, сургуулийн эрэм зорилго, онцлог, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулах, хэлэлцэх, сайжруулах, батлуулах ажлыг зохион байгуулах, эцсийн үр дүнг хариуцах;

11.3.2. Сургалт – эрдэм шинжилгээний бодлого, төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх;

11.3.3 Бэлтгэж буй мэргэжлийн нийгэм, зах зээлийн эрэлт хэрэгцээг байнга судалж, ажил олгогч нартай холбоотой ажиллан, оюутны дадлагын түшиц газруудыг сонгон, холбоотой ажиллах;

11.3.4. Эрдэм шинжилгээний бага хурал, хэлэлцүүлэг, семинар, олимпиад зохион байгуулах;

11.3.5. Сургуулийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхэд идэвх чарамайлттай оролцох;

11.3.6. Сургуулийн гадаад харилцааг өргөжүүлэхэд санаачилгатай оролцох;

11.3.7. Сургалтын чанар, зохион байгуулалт, төлөвлөлтийн хэрэгжилтэд хариуцлага хүлээх;



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

11.3.8. Мэргэжлийн эрэлт хэрэгцээ, зах зээлийн багтаамж, мэргэжил сонголтын талаар судалгаа хийж, сургуулийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд идэвх санаачлагатай оролцох.

Арван хоёр. БАГШ, АЖИЛТНУУД

12.1 Багш ажилтан нь Монгол Улсын Хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу тухайн албан тушаал (ажлын байрны тодорхойлолт)-д хамаарах ажил үүргийг захирал буюу түүний эрх олгосон этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ, контрактын үндсэн дээр гүйцэтгэнэ.

12.2 Багш эрдэм шинжилгээний ажилтан нар тухайн салбараар мэргэшсэн магистраас доошгүй зэрэгтэй байна.

12.3 Сургуулийн орон тооны багшийн албан тушаал тэргүүлэх профессор, профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлтэй байна.

12.4 Багшийн ажлын сул орон тоог нийтэд зарлаж, сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгож авна. Мэргэжлийн салбартаа тэргүүлэх эрдэмтнийг урилгаар авч ажиллуулж болно.

12.5 Багш нь Эрдмийн зөвлөлөөс баталсан “Сургуулийн багшийг аттестатчилах журам”-ын дагуу 2 жил тутум аттестатчилалд хамрагдана.

12.6 Сургуулийн багш, ажилтнууд Монгол Улсын Боловсролын хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах нийтлэг эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

12.6.1. Хөдөлмөрлөх орчин нөхцөл, сургалт явуулахад шаардагдах мэдээллээр хангагдах

12.6.2. Сургуулийн үйл ажиллагааны талаар санал гаргах, холбогдох байгууллагад тавих

12.6.3. Сургуулийн Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад журамд заасны дагуу төрөл бүрийн хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг туслалцаа авах



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

12.6.4. Энэхүү дүрэм болон холбогдох бусад дүрэм, журам, гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргүүд, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг чанартай, цаг тухай бүр хэрэгжүүлэх, дагаж мөрдөх

12.6.5. Суралцагч оюутнуудын амжилт, хөгжил, сургуулийн нэр хүндийг өсгөхүйц олон талт мэргэжлийн мэдлэг, чадвар, дадал зуршлыг бий болгож идэвхи санаачлагатай ажиллах

12.6.6. Эрдэм шинжилгээний ажлыг шинжлэх ухааны өндөр түвшинд эрхлэх

12.6.7. Олон улсын болоод үндэсний хэмжээний мэргэжлийн тэмцээн уралдаануудад оюутануудаа бэлтгэн оролцуулах

12.6.8. Сургуулийн оюутнуудын сурч боловсрох хүсэл эрмэлзлийг үргэлж идэвхижүүлжэн, сурах хөгжих нөөц бололцоог илрүүлэн, тасралтгүй хөгжүүлэх ажлыг идэвхитэй зохион байгуулах

12.6.9. Мэргэжил мэргэшлээ гүнзгийрүүлэн оюуны бүтээл туурвих, нийтлүүлэх, ном гаргах

12.6.10. Багш ажилтны ёс зүйн дүрмийг чанд сахиж, оюутан шавь нар болон хамтран ажиллагсаддаа үлгэр дууриаллыг үзүүлж ажиллах

12.6.11. Сургуульд шинээр элсэх оюутны тоог батлагдсан хэмжээнд хүргэхэд идэвхийлэн оролцох

Арван гурав. СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИД ,ХАМТЫН АЖИЛЛАГАА

13.1 Сургууль нь Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг яс үндэс, гарал үүсэл, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдлыг харгалзахгүйгээр зохих хууль тогтоомжийн дагуу элсүүлэн суралцуулна.

13.2 Оюутан (цаашид “суралцагчид” гэнэ)-ыг элсүүлэх, сургах, төгсөх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн Сургуулийн захирлын баталсан журмаар зохицуулна.



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

13.3 Суралцагчид нь Монгол Улсын боловсролын хууль болон бусад хууль тогтоомж, Сургуулийн дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг биелүүлэхээс гадна мэдээллээр хангагдах, сургуулийн удирдах зөвлөлд төлөөлөлтэй байх, сургалтын төлөвлөгөөний хүрээнд хичээлийг сонгон судлах, амжилттай суралцсаны тэтгэлэг, дэмжлэг авах, өөрийн ахуй амьдрал, сургалттай холбоотой асуудлаар санал хүсэлт таьж шийдвэрлүүлэх эрхтэй.

13.4 Сургуулийн сургалт төлбөртэй байх ба суралцагчид зохих журмын дагуу сургалтын төлбөрөө төлөх , тэтгэлэг авах, хөнгөлөлт эдлэх эрхтэй.

13.5 Суралцагчид нь ёс зүйн дүрэмтэй байна. Ёс зүйн дүрмийг чанд дагаж мөрдөнө.

13.6 Суралцагчдыг элсүүлэх, шилжүүлэн авах, хасах, төгсгөх, улируулах, чөлөө олгох асуудлыг журмын дагуу Сургалтын алба судалж, эцсийн шийдвэрийг Сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

13.7 Өөр сургуулиас тус сургуульд шилжин сурах оюутны кредит цагийг хүлээн зөвшөөрөх журмыг сургуулийн сургалтын холбогдох журамд тусгана.

13.8 Сургуулийн суралцагчид нь нэгдсэн нийтлэг хувцастай байж болно.

13.9 Сургууль нь анх элсэн орж буй суралцагч бүртэй сургалтын гэрээ байгуулна. Дээд сургуулийг төлөөлж сургуулийн Захирал суралцагчтай гэрээ байгуулна.

13.10 Сургууль нь дэргэдээ Оюутны зөвлөл, Оюутны эцэг, эхийн зөвлөл, Төгсөгчдийн холбоо, Оюутны карьер төлөвлөлтийн төвтэй байж болох ба тухайн зөвлөл, холбоо, төвийн үйл ажиллагааг сургуулийн санхүүгийн нөхцөл байдалд тулгуурлан тодорхой төсвийн хүрээнд дэмжин ажиллана.

Арван дөрөв. СУРГУУЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТАТВАР, САНХҮҮЖИЛТ БА ХЯНАЛТ

14.1. Сургуулийн санхүүгийн жил нь тухайн жилийн 7-р сарын 1-нээс эхлэн /эхний жилийн хувьд бол энэхүү гэрээ хүчингүй блох буюу гэрээний заалт ёсоор татан буулгасан өдөр/ дараа оны 6-р сарын 31-ний өдөр дуусна.

- 14.2. Сургууль нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, газар эдэлбэр, түрээсийн төлбөрийг зохих ёсоор төлнө.
- 14.3. Сургуулийн санхүүгийн болон статистикийн бүртгэлийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтөлнө.
- 14.4. Сургууль нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу элэгдэл хорогдлын шимтгэлийг байгуулна.
- 14.5. Сургууль нь Монгол Улсын аль ч банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй.
- 14.6. Сургуулийн санхүүгийн тайлан тэнцлийг холбогдох татвар, хяналтын байгууллагад Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шалгуулах үүрэгтэй бөгөөд холбогдох баримт материалыг шаардсаны дагуу гаргаж өгнө.
- 14.7. Сургууль нь тухайн санхүүгийн болон хичээлийн жилийн санхүү, сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааны тайлан тэнцлийн хамт холбогдох татвар, хяналтын байгууллагад үйл ажиллагааныхаа товч тайланг зохих маягтын дагуу Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын газарт тус тус гарган өгч байх үүрэгтэй.
- 14.8. Санхүүгийн тайлан тэнцлийг улирал, жилээр гаргана. Уг баримтыг Монгол хэл дээр үйлдэнэ.
- 14.9. Сургуулийн бүртгэл тооцооны нэгжийг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж байгаа бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, өр авлага нь анх оруулсан валютаар байна. Тэдгээрийг нягтлан бодох бүртгэлийн дансанд бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхдээ Монгол банкны тухайн үеийн албан ханшийг хэрэглэнэ.
- 14.10. Сургуулийн бүх төрлийн даатгалыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын байгууллагад даатгуулна.

Арван тав. СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООХ

- 15.1. Сургуулийн үйл ажиллагааг дараах тохиолдолд зогсоож, татан буулгах асуудлыг Удирдах зөвлөлийн саналаар үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч шийдвэрлэнэ. Үүнд:



Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн №0045 тоот шийдвэрийн Хавсралт№1

15.1.1. Үйл ажиллагааны анх тохирсон болон сунгасан хугацаа нь дууссан

15.1.2. Сургуулийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, хүний нөөц болон оюутны тоо хэт цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон

15.1.3. Санхүүгийн хувьд алдагдалтай ажиллаад 6-аас дээш сар болсон, энэ тохиолдолд хөрөнгө оруулагч нэмэлт хөрөнгө оруулах боломжгүйгээ мэдэгдсэн

15.1.4. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулагчийн анх оруулсан хөрөнгийн хэмжээ 30 хувиас дээш хэмжээгээр багассан, үнэлэгдэх чанараа алдсан

15.1.5. Энэхүү дүрмээр дэвшүүлсэн зорилт, хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрсэний улмаас сургууль үйл ажиллагаагаа цаашид явуулах ач холбогдолгүй гэж үзвэл:

15.1.6. Эрх бүхий байгууллагын хуульд нийцсэн шийдвэрээр

15.2. Сургуулийн үйл ажиллагааг зогсоох тохиолдолд өр төлбөрийг төлсөний дараа үлдэх хөрөнгийг нь үүсгэн байгуулагчид хуваарлана. Эсвэл үүсгэн байгуулагчийн хүлээн авахуйц валютаар төлбөр тоцоо хийхээр тохирч хөрөнгийг худалдана.

15.3. Сургуулийн үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд үүсгэн байгуулагч дээд сургуулийг татан буулгах шийдвэрийг гаргаж, татан буулгах комиссыг сургуулийн үүсгэн байгуулагчийн саналаар Удирдах зөвлөл томилно.

15.4. Татан буулгах комисс сургуулийн бүх төлбөр тооцоог хийж нийтэд мэдээлснээс хойш 20 хоногийн дараа үүсгэн байгуулагчид эцсийн тооцоог хүлээлгэн өгнө.

15.5. Дээд сургуулийг татан буулгах ажиллагаа дуусмагц татан буулгах комисс тайлан гаргана.

15.6. Татан буугдсаны дараа сургуулийн архивыг Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яаманд 20 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

Арван зургаа. АЖИЛЛАХ ХУГАЦАА

16.1. Сургууль үүсгэн байгуулагдсан буюу улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

16.2. Сургуулийн ажиллах хугацаа нь Монгол Улсын боловсролын тухай хуулийн 23,24,25-р зүйлд зааснаар тодорхойлогдоно.

Арван долоо. ДҮРМИЙН ХЭЛ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

17.1. Энэхүү дүрмийг Монгол, Англи, Солонгос хэлээр 3 хувь үйлдсэн байх бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

17.2. Сургуулийн албан ёсны хэл нь монгол хэл байна.

17.3. Дүрмийг батлах, хүчин төгөлдөр болгох, хэрэгжүүлэх, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийг хүчингүй болгох асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

17.4. Энэхүү дүрэмд үүсгэн байгуулагч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

-----X-----